



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 0255

Улаанбаатар хот

Хэрэглэлийн нислэгийн журам  
хүчингүй болгох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7, 24 дүгээр зүйлийн 24.2, 11 дүгээр зүйлийн 11.1, ИНД-95 "Хэрэглэлийн нислэгийн дүрмээр буултын ойртолт үйлдэх ба сансрын навигац ашиглах дүрэм"-ийн 95.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нисэхийн аюулгүй ажиллагаа хяналт, зохицуулалтын албаны байцаагчийн 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 55/18 дугаар дүгнэлтийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2014 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/106 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Увс аймгийн "Дэглий цагаан" нисэх буудлын хөөрч буух зурвас 31-т А/В ангиллын агаарын хөлөг чиглүүлэх радио станц ашиглан хэрэглэлээр ойртолт үйлдэх журам, 2 дугаар хавсралтаар баталсан С ангиллын агаарын хөлөг чиглүүлэх радио станц ашиглан хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Дээрх нислэгийн журмуудыг хүчингүй болсон талаар зарлан мэдээлэхийг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба /П.Ариунгэрэл/-нд даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Ё.Эрдэнэбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН